



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/630

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, сумдын төвөөс алслагдсан хөдөөгийн багийн малчдын малын чанар, ашиг шим, эрчимжсэн мал аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд техник технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх, малчдын амьжиргааг дэмжиж, ажлын байр бий болгох чиглэлээр малчдаас гаргасан санал санаачлагыг дэмжих зорилго бүхий "ШИНЭ ХӨДӨӨ-2024" малчдын зөвлөгөөнийг 2023 оны 12 дугаар сарын 27-нд "Чингис хотод" зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Ж.Энх-Амгалан Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга

Нарийн бичгийн

дарга: Г.Гантөмөр Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

Гишүүд: Н.Зоригтбаатар Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Нямдаваа Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Г.Ариунчимэг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, Хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Ц.Эрдэнэболд Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэлийн ажилтан


Г.Тэмүүжин Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа урирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Б.Саранцэцэг Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа аж ахуйн албаны дарга

Д.Цогт-Эрдэнэ Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын дарга

2.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн хэсгийн ахлагч (Ж.Энх-Амгалан)-д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ